

**Монголчуудын нүүдэллэлт,
шалтгаан, сургамж**

Доктор /PhD/, профессор Л.Чулуунбаатар

XX зууны сүүлийн хагасаас хүн төрөлхтний хөгжил дэвшилд чанарын цоо шинэ үе шат эхэлсэн гэж үзэж болох байна. Учир нь дэлхий дахинд “хүйтэн дайн”-ы үе шувтарч, улс төр, үзэл суртлын сөргөлдөөн төгсгөл болж, оюуны багтаамжтай үйлдвэрлэл зонхилж, шинэ “гурав дахь давалгаа” буюу мэдээллийн эрин үеийн үндэс суурь тавигдсан билээ. Бас хөгжлийн төв рүү тэмүүлэх хүч саармагжин, төвөөс зугатах хүч илт давамгайл үйлчилж байна. Хүмүүсийн үзэл бодол, хүсэл тэмүүлэл ч их өөрчлөгдсөн юм. Энэ нь урьд өмнө үзэж байсан зарим асуудлыг зайлшгүй эргэн харж, тодорхой хэмжээгээр эргэцүүлэхийг зүй ёсоор шаардаж буй. Эдгээр асуудлын дотор нүүдэлчид, нүүдлийн соёл иргэншлийн тухай үзэл, ойлголт багтаж байна. Энэ учраас нүүдэл, нүүдэлчдийн хувь тавилангийн тухайд монголчуудын бодит жишээн дээр тулгуурлан өгүүлэх гол зорилтыг дэвшүүлэв. Монголчуудын нүүдэллэлт нь зөвхөн мал аж ахуйтай холбоотой биш, бас нийгэм, улс төрийн үйл явцтай тодорхой хэмжээгээр хамааралтай байсныг товч харуулахыг хичээв.

“Хүн төрөлхтний түүх нүүдэлчдээс эхтэй” хэмээн их сэтгэгч Г.Ф.Гегель тэмдэглэсэн бол “малжих бүх ард түмэн анхандаа нүүдэллэн яваа айл хүмүүс”-ийг нүүдэлчин гэдэг учраас **нүүдэл** нь нэгд, “нутаг сонгож нэг газраас нөгөө газарт шилжих хөдөлгөөн” /2,393/ хэмээн толь бичигт тодорхойлжээ. Иймээс нүүдэл бол айл өрхийн нутаг сэлгэхээс эхлээд угсаатан, улс үндэстний зарим хэсэг нь өөр орон нутагт шилжих шилжилт зэргийг багтаасан өргөн хүрээтэй ойлголт юм. Хүн төрөлхтний түүхэнд нүүдэл, суурьшил үргэлжлэн, тодорхой шалтгааны улмаас шинэ газар нутагт шилжсэн баримт жишээ олон бий. Өдгөөгөөс 30-аад мянган жилийн тэртээ монгол хэв шинжийн индианчууд Азиас Аляскаар дамжин одоогийн Америк тивд очсон бол V зууны үед “ард түмнүүдийн их нүүдэл” болжээ. Энэ бүхэнд нөлөөлсөн дотоод хүчирхэг түлхэц байсан нь маргаангүй. Уг түлхэц нь байгаль цаг уурын нөлөөлөл болон нийгэм улс төрийн үйл явцтай шууд холбогдсон бодит үндэслэлтэй байв. Энэ бүхнийг эргэцүүлбээс, нүүдлийг дотоод, гадаад гэсэн хоёр үндсэн хэсэгт ойлгох ёстой. Дотооддоо гол төлөв байгаль, газар орон, ус, цаг уурын шууд хараат байсан бэлчээрийн мал аж ахуйг өсгөн үржүүлэх хийгээд улс орны дотор үүссэн зөрчил тэмцэл зэргээр нөхцөлдөж байжээ.

Монголчууд нүүдэлчин болсон нь амьдралын бодит хэрэгцээ шаардлагатай шууд холбоотой түүхэн зайлшгүй үзэгдэл байв. Түүхийн шинжлэх ухааны доктор Д.Гонгор асан бичсэн нь: “нүүдэллэн аж төрөхүй ёсон нь хүн төрөлхтний хөдөлмөрийн хувиараас үүсч, түүнтэй уялдсан мал аж ахуйн үйл ажиллагааны дотор манай монголчууд нөгөө суурьшмал ард түмнээс чухам юугаараа онцлог вэ хэмээхүл зуны цагт бол хур тунадас орохгүй, өвс ногоо, хужир усаар дутмагдан газрын хөрс гандан хуурайшиж, өвлийн тэсхийм хүйтэнд бол дулаан нөмөр бууц бэлчээр цас мөсөнд хучигдаж өвс ургамал идэгшин давтагдах, хаврын цагт бол нөөц хагд, хур өвс барагдах, намар болохул сөл хөөх, ургамлын бүтэц бүрхээс малын төрөлд тохиромжгүйдэх, уул нутагт ган зуд зэрэг байгалийн гачаал даван туулах найдваргүй нь урьдчилан мэдрэгдэхээс гадна аль ч улиралд хүн малын элдэв өвчин тахал гарах, өтөг бууц шатах, гал усны зовлон тохиолдох, цагийн их хөл үймээн дэгдэх тэргүүтнээс болдог байна.” /3,308/ гэж дүгнэжээ.

Дээр дурьдсан шалтгаануудын улмаас монгол оронд ган, зудын гамшиг олон удаа тохиолдож, нүүдэлчид мал сүргээ авран хамгаалахын тулд хол, ойр нүүдэл их хийж байжээ. Тухайлбал, “МЭӨ II зууны үед монгол нутаг хойт талаасаа буюу хангайгаас эхлэн хуурайшиж, тэр нь хээр талаа нөмөрч, бүхэлдээ хүн, мал хоёр байхын аргагүй болж, Хүннүчүүд урагш нүүж, Хятадын нутагт нэлээд лав орж суурьшин, хятадын буюу өмнөд Хүннү хэмээгдсэн нь бий. Энэ нь монголын байгаль, цаг агаарт хангай билгийн үүрэг гүйцэтгэж чадахаа больж, монгол нутагт аргын буюу ус, төмөр махбодтой цаг агаар ноёрхсон гэсэн үг. Тийм цаг агаар хэдэн арван жилийн дараа өөрчлөгдөж, элсэн

цөл нь говь, говь нь хээр, хээр нь хангай болон солигдсоор өнөөгийн энэ цаг агаарт эргэн орсон түүхтэй аж." /4,80/ Бас "Уйгур улсын мөхлийн шалтгааныг бүрэн ойлгохын тулд байгалийн бэрхшээл зуд турхан болсныг дурьдахгүй өнгөрч болохгүй юм. Нангиад сурвалж бичгүүдэд 839 онд "... хэдэн жил дараалан цас их унаж, өлсгөлөн, өвчин тахал дэгдэж, үхсэн хонь газраар дүүрэв" гэж тэмдэглэжээ. /5,35/

Их Монгол болон Юан улсын үед ч байгалийн гамшиг болж, нүүдлийн мал аж ахуйд ихээхэн хохирол учруулж байжээ. "1248 онд ган болж, голын ус хатаад, хөдөөний өвс өөрөө ноцож үхэр, морь арав тутмаас нэг нь үхсэн" /6,20/ бол 1307-1308, 1339-1340 онд мөн ган болж "хонь, морь цөм үхжээ" гэж Юан улсын сударт тэмдэглэжээ. /7,124,324/

Ийнхүү ган, зудын бэрхшээл тохиолдох нь манай орны нутаг дэвсгэр эх газрын эрс тэс уур амьсгалын бүсэд хамаарагддаг, хөрсний хучлаг нимгэн, бэлчээрийн даац муутай, ус, чийгний хангамж үлэмж дутагдан байсан зэрэгтэй шууд холбоотой юм. Иймээс нүүдэлч малчид нутаг, орныхоо эл өвөрмөц байдлыг танин мэдсний үндсэн дээр "ус өвсөө нэгтгэх" /8,2/ зорилгоор нүүдэл хийх уламжлалтай болсон юм. Монгол орны хангай, говь, тал хээрийн бүсийн малчид нутаг орныхоо өвс ургамлын ургац, ус, хужрын байдлыг харгалзан нүүдлийн чигээ тогтоож "нутаг сэлгэх", "товших", "өртөөлөх" зэрэг арга маягаар /9,12-13/ нүүдэллэж байв. Дээр үеэс уламжлан ардуудын дунд "нүүхийн өмнө бэлчээрээ, буухын өмнө бууриа сонго, нүүдлийн хүнээс нутаг асуу, нүүсний мал тарган, суусны бие амар" гэж хэлэлцэж иржээ.

Монголчууд хүчирхэг, нөлөөтэй байх үедээ өөрийн орны нутаг дэвсгэрээс гадагш, алсад нүүдэл хийдэг бол энэ нь XIV зууны дунд үеэс хойш улам бүр хумигдсан хэдий ч 1950-иад оны үед оторчид Алашаны говь хүртэл урт зам туулан нүүдэллэж байжээ. Ер нь манжийн ноёрхлын үеэс гадагш нүүдэл хийх боломжгүй болсон учраас улс орныхоо нутаг дэвсгэрийн дотор нүүдэл суудлаа зохицуулж, газар, тэнгэр "аргадах", цаг улирлыг урьдчилан шинжих зэрэг янз бүрийн арга хэрэглэж иржээ. Жишээ нь: "Түшээт хан аймгийн чуулган даргын газраас 1794 онд Их Хүрээний орчмын газар ба ялангуяа говь газарт бороо орсонгүй, ган болсноор тус аймгийн засаг хошууд ба хутагтын шавь нар болон бүх ардын мал адуус, өвс, ногоогүйд үнэхээр чармайхын туйлд хүрэв гэж хотгойдын гүн Батжаргалын биеийг зад барих, мэргэн сайн өвс тэргүүтнийг авахуулан ирүүлж бороо оруулах болов уу гэж Их Хүрээний сайд нарт бичиж байсан байна. Энэхүү зад барих гэдэг бол нэгэн зүйл мухар сүсэг бөгөөд Монголд ихээхэн дэлгэрсэн ажээ. Бороо оруулах ид шидтэй ямар нэгэн өвс чулуу байдаг. Түүнийг тахиж уншлага уншиж бороо оруулж болно гэдэг байв." /10,108/. Дашрамд дурьдахад, "задын чулуу, зад өвсийг ашиглан зад барьдаг хүмүүс байсан тухай яриа их бий. Эртний чулуун зэвсгийн үлдэгдэл болон болорын талстыг задын чулуу гэх бөгөөд тэр нь янгир ямаа, хойлог шувууны биед байдаг гэдэг. Харин зад өвс бол алтан тэвнэ, мэргэн гүнж гэдэг ургамал аж. Зад барих гэгчид ардын мэргэн ухааны нэгэн увьдас нуугдаж байгаа билээ" /11,664/. Дээр үеэс уламжлан нүүдэлч түмний ёс заншлын дотор уул овоо тахиж, намрын улиралд өндөр уулын орой дээр гарч, үүлс, тэнгэрийг ажиглах, мал, амьтан, ахуйн зүйлсээр цаг агаарын үзэгдлийг шинжих зан үйл чухал байр суурь эзэлдэг бөгөөд өнөө үед ч хэрэглэгдэж байна.

Нүүдэлч малчдын арга ухаан үлэмж төгс, ёс уламжлал нэн эртнээс улбаатай болохоор энэ өгүүлэл төдийд тэр бүрийг тоочих боломжгүй юм. Нүүдэл бол бэлчээр нутагтай шууд холбогдсон үйл ажиллагаа маягаар илэрч, улмаар бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх үндсэн арга болж иржээ. Ахуй, амьдралын ийм өвөрмөц хэв маягтай ард түмнүүдийг **нүүдэлчид** гэж нэрлэдэг билээ. Гэвч 1970-аад оны сүүл үе гэхэд, Ази Африкт нүүдэлчин, хагас нүүдэлчин 28 улс байсан бол одоо бараг суурьшилд шилжсэн нь нийгмийн хөгжлийн зайлшгүй бодит шаардлага, байгаль, цаг уурын нөлөөлөл зэрэгтэй холбоотой бололтой.

Нүүдлийн уламжлалт ёсыг улиран өнгөрч буй үзэгдэл хэмээн олонхи эрдэмтэд судлаачид үзэж байна. Энэ бол бидний ойлгож байгаагаар хөгжил дэвшлийн шалгуураар соригдож, зайлшгүй үеэ өнгөрөөх үзэгдэл мөн боловч бэлчээрийн мал аж ахуй байх шаардлагатай бол нүүдлийн тухай ямар нэгэн хэмжээгээр ярих л болно.

“нүүдлийн байдал бол дэлхий дахины хэмжээний бөгөөд гурван мянган жил орчим оршин буй үзэгдэл юм. Тэр нь хүн байгалийн өөрчлөгдсөн нөхцөлд зохицох арга болж үүсээд, мөн тэр шалтгаанаараа биднийг харсаар байтал арилж байгаа юм” /12.2/ гэж нэрт эрдэмтэн Л.Гумилев нотлож бүхийг чухамхүү бэлчээр нутаг сонгон тохируулах бодит хэрэгцээ шаардлагатай холбон авч үзвээс анхаарч үзүүштэй зүйл мэт. Харин байгаль, цаг уурын эрс өөрчлөлт цаашид улам гүнзгийрвэл нүүдлийн утга агуулга үндсэндээ алдагдах нь ойлгомжтой.

Нүүдлийн байдал хэдий хурдац удаантай ч атугай өөрчлөлт, хөгжилд өртөж иржээ. /13,25/ гэдэгт тал өгөхийн сацуу нүүдэл бол хүрээлэн байгаа байгаль орчныг хамгаалах нэгэн арга учраас байгальтай зохицох, зүй зохистой ашиглахад өнөөгийн өөрчлөлт шинэчлэлтийн үндсэн дээр түүнийг баяжуулан төгөлдөржүүлж хэрэглэвэл илүү үр дүнтэй юм.

Гэвч нүүдлийн нөхцөл байдлыг өөрчлөх нэр шаргуу тэмцэл бүр 1920-иод оны дунд үеэс манай оронд өрнөж, өдгөө бүр ч гүнзгийрсэн гэж хэлж болно. Тус оронд 1924, 1931 онд орон нутгийн засаг захиргааны хуваарийг өөрчилснөөр, уламжлалт тогтолцоо болох хангай, тал хээр, говийн бүсийг хослуулан нүүдэллэх явдла хязгаарлагдав. 1950-иад оны эцсээр ардын аж ахуйтнуудыг хоршоололд нийтээр нь хамруулж, хөдөө аж ахуйн нэгдлийн гишүүн болгож хувийн мал хөрөнгийг нь нийгэмчлүүлж, малчдад нэг төрлийн олон малыг суурьлан маллуулснаар нүүдлийн урьдл өмнөх уламжлал алдагдахад хүргэсэн билээ.

Улмаар Монголд атар газар эзэмшиж, хот суурин олноор байгуулагдаж, үйлдвэр завод, уул уурхай, зам харилцаа өргөжснөөр бэлчээрийн эдэлбэр газрын хэмжээ ихээхэн хумигдаж, түүнтэй зэрэгцэн нүүдэллэх нь ч багасч, хүмүүс хот руу шилжиж, хөдөө нутаг эзгүйрэн үлдэж, хүн малын хөл татарсан юм. Бэлчээрийн мал аж ахуйг хамгийн хямд зардлаар, үлэмж үр ашигтай эрхлэхэд нүүдэллэх арга нэн тохиромжтой байсан бөгөөд байгалийн элдэв гачаалыг даван туулахад ч ихээхэн ач холбогдолтой байв. Тухайлбал, урт хөлийн малыг оторлох, уулын оройн бэлчээрийг ашиглах, малд тарга хүч авахуулах зэрэг олон сайхан туршлагыг нүүдэлч малчид эзэмшиж, хойч үедээ өвлүүлсэн юм. Ийм учраас байгалийн шууд бүтээгдэхүүн болох бэлчээр нутгийг мал сүрэгтэй холбох, түүгээр зогсохгүй малын төрөл тус бүрийн хоорондын шүтэлцээ, хүн малын харилцан хамаарал зэргийг байгаль нийгмийн бодит хууль, түгээмэл зүй тогтолтой нягт уялдуулан зохицуулдгаараа нүүдэлчид хүн төрөлхтний соёл иргэншлийн түүхэнд зохих хувь нэмэр оруулсан билээ.

Нүүдэл нь зөвхөн бэлчээрийн мал аж ахуйг эрхлэн хөтлөх төдий ойлголт биш. Энэ нь монголчуудын оршин тогтнох, бусдын довтолгооноос өөрсдийгөө хамгаалах, гадагш байлдан дагуулах, сүр хүчээ илтгэн харуулах, ажиллаж амьдрах зэрэг нийгэм улс төрийн олон талын учир шалтгаантай салшгүй холбоотой, нийгэм-түүхийн үзэгдэл юм.

Он цаг улирах хирээр хүчирхэг Хүннү гүрэн суларч, өмнөд, умард болон хувааагдаж, эцэст нь удам гарал нэгтэй Сүмбэ нарт өөрийн байр суурийг тавьж өгсөн тэр үед Хүннүгийн зарим аймгууд баруун тийш нүүдэллэн одсон аж. Тэд Ромын их эзэнт улсыг мөхөлд хүргэсэн аймгуудын нэг болох дорно зүгийн “варвар” /бүдүүлэг/ нэрээр Ромын түүхэнд тэмдэглэгдэн хоцорчээ. Хүннү нэрээр тэмдэглэгдсэн, зэвсэглэсэн морьтон нүүдэлчид дорно зүгээс Ромыг уулгалан довтолж, улмаар тэрхүү эзэнт улсыг задран бутрахад хүргэсэн байна. МЭ 434 оноос Кавказаас Рейн мөрөн хүртлэх өргөн уудам нутгийг эзэлсэн Хүннү удмын хан эзэн Аттил /тэнгэрийн ташуур/ /434-453/ эзэнт улсаа байгуулах, Европын түүхэнд гүнзгий ул мөр үлдээж, тухайн үеийн олон улсын харилцаанд зохих нөлөө үзүүлсээр байжээ./14,382/. Бас Нирун нарын зарим нь VI зууны үед урьдын Хүннүгийн замаар тэдний адил баруун тийш нүүдэллэн, Дундад Ази, Европын түүхэнд VIII зуун хүртэл авари /обори/ нэрээр тэмдэглэгдэн дэлхийн улс түмнүүдийн амьдралд өөрийн ул мөрөө үлдээж байсан түүхтэй. /14,383/. Мөн VIII зууны үеэс Түрэгүүдийн зарим хэсэг нь баруун тийш нүүдэллэн, Турк-Сельджукуудтай цус холилдон, Османы эзэнт улсыг байгуулсан билээ. Эдгээр нүүдэллэлтийн шалтгаан нь Хүннүгээс эхлээд, нүүдэлчид, бэлчээр нутаг эрж явсан биш, харин монгол нутагт байсан

янз бүрийн овог, аймгуудын өөр хоорондын зөрчил тэмцэл ихээхэн хурцдаж, зарим хэсгээ шахамдуулж, улс төрийн нөлөөлөл, оргилон өрнөх үйл явц өрнөсөн зэрэгтэй холбоотой болов уу.

Монгол удмын аймгууд бас зүүн тийш нүүдэллэн явсан тухай баримт байдаг. Тухайлбал, VI-VIII зууны үед монгол овог аймгууд, түрэгчүүдэд цохигдон, хүн амын олонхи нь алагдаж, зөвхөн хиян нукус хэмээх хоёрхон овог аймгийн цөөн хүмүүс үлдэж нутаг орноорон ул хад, ой модоор хүрээлэгдсэн гаднаас зөвхөн ганцхан давчуу зөрөг замаар нэвтрэн орох бөглүү газар очиж тэндээ 400-аад жил амьдран суужээ. Судалгааны баримтаас үзэхүл, "Мэнгу шивэй нь Эргүнэ голын өмнө хөвөө, хянганы давааны умард хэсгийн баруун бэлээр нутаглаж байжээ. Энэ газар нь газар зүйн байршил, орчин нөхцлөөрөө "Эргүнэ кун" мөн байж болохоор байна" /16,10/ гэсэн таамагнал дэвшүүлжээ. Түрэгчүүдэд шахагдсан монгол овог аймгууд зүүн тийшээ нүүдэллэсэн болон хятад сурвалжийн мэдээ сэлтийг нягталбал, Эргүнэ Күн гэдэг газар монгол нутгаас зүүн, зүүн хойд зүгт байсан байж болох юм.

VIII зууны үе болоход монгол нутаг дахь түрэгчүүдийн ноёрхол эцэслэж, Уйгарчууд зонхилох байр суурьтай болсон ч, Эргүнэ Күнгийн орчмоос монгол аймгууд уван цуван нүүдэллэсээр эх нутагтаа буцаж иржээ. "Монголын нууц товчоо"-нд: "Чингис хааны язгуур, дээд тэнгэрээс заяат төрсөн Бөртэ-чино, гэргий Гоомаралын хамт тэнгис далайг гаталж ирээд Бурхан Халдун ууланд нутаглаж" /17,25/ байсныг тэмдэглэсэн билээ.

Монголчуудын нүүдэллэлт нь өөрсдийн амь биеийг хамгаалах төдий байсангүй, "цагийн их хөл үймээн"-ий үед дэлхийн улс түмнүүдийн амьдралд гүнзгий нөлөөлж, бас монгол угсаатны нэгдэл нягтрал бүрдэхэд шууд түлхэц үзүүлсэн байна. Урьдын адил тархай бутархай байвал бусдын түрэмгийлэлд хялбархан эзлэгдэнэ гэдгийг ухаарсан монголчууд XIII зууны эхээр нэгдэж, Их Монгол улсыг байгуулсан юм. Тухайн үеэс монголчуудын сүр хүч бадран, оргилон өрнөх үйл явц гүнзгийрч, гадагш байлдан дагуулалт хийж олон газар орныг захиргаандаа оруулжээ. Иймээс хөрш зэргэлдээ болон дэлхийн олон оронд монголчуудын удмынхан бөөн, цөөнөөрөө нүүдэллэн очиж суурьшиж байсныг судалгааны баримт тодорхой харуулж байна. /Хавсрал №1-ээс үзнэ үү/ тэр үеийн нүүдэллэлт бол бусдад шахагдаж, амь улжсан маягийн биш, их цэргийн ар тал, ялан дийлэгчдийн сүр хүчний илэрхийлэл болж байв. Харамсалтай нь, монголчуудын ноёрхол төгсгөл болоход, их цэргийн үлдэгдэл, ар талынхан эх нутагтаа буцаж ирж чадалгүй тэндээ үлдэж хоцорсон ажээ. Энэ бол бодит үнэн, гашуун сургамж болой.

Монгол оронд улс төрийн бутрал гүнзгийрч, улмаар манжийн түрэмгийлэл нүүрлэж ирэхэд, 1620-иод оноос эхлэн баруун монголчууд Орос руу нүүж, 1635-1636 онд Халхын Цогт хунтайж, Ойрадын Гүүши хан хэмээх Төрбайх нар их цэрэг, албат харъяатнуудаа дагуулан, Хөх нуурын зүг нүүдэллэн явжээ. Мөн өндөр гэгээн Занабазар, Түшээт хан Чахундорж болон манжид дагаар орсон феодал ноёдыг дагаж олон өрх, хүн ам эх нутгаасаа харийн газарт нүүдэллэн очжээ. Бас 1920-1930-аад оны үед нутаг орноосоо дүрвэн нүүсэн хүмүүс Европоор дамжин АНУ-д очсон байна.

Энэ бүхнээс үзэхэд, эрт үеэс эхлэн монгол удмын хүмүүс эх нутгаасаа гадагш нүүдэллэх, эргэж ирэх, дүрвэж зайлан одох явдал үлэмж байжээ. Монголчуудын хуучны үгэнд: "Бусдын эрхэнд жаргахаар, өөрийн эрхээр зов" гэж байдаг ч тухайн цаг үеийн араншин, нөлөө бүхий хүчний бодлого, үйл ажиллагааны улмаас харийн газар одсон олон хүн ард эргэж ирж чадалгүй, тэр нутагтаа суурьшсан байна. Энэ бол нэг талаар эмгэнэлтэй хэдий ч хойч үеийнхэндээ "дассан газрын даавуу зөөлөн" гэгчийг санагдуулсан бодит сургамжтай юм.

Нүүдлийн иргэншил нь зөвхөн аж ахуйг эрхлэн хөтлөх арга төдийгүй, материал баялгийг үйлдвэрлэн бүтээх, хуваарилах, нийгмийн үйлдвэрлэлийг зохион байгуулах өвөрмөц арга, түүнд тохирсон мэдлэг ухаан, итгэл бишрэл, ёс суртахуун, гоо сайхны үзэл баримтлалыг өөртөө багтаасан тогтолцоо мөн /18,58/ ажээ. Ийм тогтолцоог бүхэлд

нь өөрчлөх асуудал бол улс орны хөгжлийн нэлээд өндөр түвшинд шийдвэрлэгдэх учиртай бөгөөд “сэтгэл хөдлөл”-ийн хөөрлөөр шийдэж болдоггүй гэлтэй.

Нүүдлийн нөхцөлд монголчууд эртнээс нааш махан хоолны 200, цагаан идээ, цагаан хоолны 150, боов идээний зүйл 50 гаруй, бүгд 400 гаруй нэр төрлийн хоол хүнс хэрэглэж ирсэн /19,308/ байна. Ер нь “нүүдлийн соёл иргэншлийг газар тариалантай харьцуулбал, түүнээс илүү эдийн засгийн үр ашигтай зэрэг нүүдэл зүй /номадизм/-д тодорхой давуу талууд бий” /20,185/ гэдгийг зарим эрдэмтэд онцлон тэмдэглэжээ. Дэлхий дахины болон манай орны хөгжлийн хүрсэн түвшин, бодит шаардлагыг харгалзан, суурьшлын нөхцөл, боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ монголд тодорхой хугацаанд нүүдлийн хэв маягийг зохистой хослуулах, уламжлал, шинэчлэлийн давуу талыг илэрхийлэх зөв бодлого баримталж хэрэгжүүлэх нь зүйтэй юм.

Бидний бодоход, мэдээллийн шинэ эрин үе эхлээд байхад, монголчууд нүүдлийн мал аж ахуйтайгаа зууралдсаар байгаа нь хоцрогдсоны үндсэн шинж гэж үзэхээс өөр аргагүй биш, байгаль цаг уурын бодит нөхцөл, эрс өөрчлөлт, зах зээлд шилжих хүнд сорилт зэрэг бусад олон хүчин зүйлтэй шууд холбогдож байна. Манай нөхцөлд нүүдлийн уламжлалт арга туршлага дээр тулгуурлан, эдийн засгийн дэд бүтэц, хөдөөгийн нийгэм, ахуй, соёл боловсролын хөгжлийн явцад ардын аж ахуй үүсч, хотжих үйл явц саармагжин хөдөө орон нутагт мал аж ахуйд шүтсэн жижиг, дунд үйлдвэрүүд байгуулагдах боломжтой юм. Тиймээс нүүдэл бол цаг агаарын тохиромжтой үед эрчимжсэн мал аж ахуйд зардал хэмнэх, байгалийн бэлэн нөхцлийг ашиглах гол арга, нүүдэлчид бол орчийн үеийн шинжлэх ухаан, техникийн дэвшлийн ололтыг хүртсэн, эрчимжсэн мал аж ахуй эрхэлсэн үйлдвэрлэгчид болох ирээдүйтэй билээ.

Эцэст нь тэмдэглэхэд, өмнөд Солонгосын нэрт сэтгүүлч Ким Жон Рэгийн бичсэнчлэн, “хашаа хэрэм барин суурин суугчид мөхөж, нутаг сэлгэн нүүдэллэгчид үл мөхмөй”. “Аз жаргалгүй хийгээд аз жаргалтай хүмүүсийг зааглан тусгаарлагч суурин соёл иргэншлийн хэрэм цайз дахин нурж, хүн төрөлхтний түүх бас дахин хар салхи мэт уухилан давхилах үе, шуурга салхины өлгий нутгийн нүүдлийн үе рүү шилжин орж байна. Бүх л хэрэм цайзнууд нурж, улс орны хил зааг устаж, суурин амьдралын хэм хэмжээ үүл мананд умбан завхарч үгүй болно. Хэрэм цайзан дотроо амар тайван амьдрах гэсэн хүсэл эрмэлзэл талаар өнгөрөх нь лавтай. /22,353/

Эрчимжсэн аж ахуйтай хөдөө нутаг бол хүн төрөлхтний амьдрах орон зай, нүүдэллэлт нь аж төрөхийн шинэ маягийн арга, нүүдэл нь оршихуйн утга агуулга болой.

Хавсралт №1

Монголчууд дэлхий даяар тархсан нь

Улс, муж, гачаа суурины нэр	Хүн амын ойролцоо тоо	Угсаатны гарал үүсэл, тайлбар
БНХАУ, Синьцзян /СУӨЗО/	120 мянга	Ойрад Монголын үлдэгдэл хүн ам, Манжийн өмнөд ба зүүн Монголоос нүүлгэж аваачсан хүн ам
Хөх нуурын автономит муж	50.5 мянга	Гүүши хаан хэмээх Төрбайх, Цогт тайж нарын дагуулж очсон хүн амын үлдэгдэл хойчис
Ганьсу муж	4 мянга	Галдан бошигтын дайнаас дайжиж Хөхнуураас нүүж очсон хүмүүс голлоно.
Өмнөд Хятадын Юньнань муж	5 мянга	1254 онд Хубилай хаан өмнөд Хятадыг эзлээд явахдаа үлдээсэн Урианхайдай ноёны 20000 цэргийн үлдэгдэл
ОХУ	1620-иод оноос эхлэн баруун монголчууд Орос руу нүүж эхлэв.	
Бусад Холбооны байсан улсууд	420 мянга	Зүчи, Цагадайн эзэмшлээс үлдсэн хүмүүсийн хойчис, 1930-аад оны дүрвэгсэд, цөллөгийнхөн
Халимагийн БНУ	174 мянга	1630-аад оноос нүүж очсон торгууд, өөлд, цөөн хошууд, Дөрвөд угсаатан
АНУ	2 мянга	Дэлхийн I, II дайны үед Турк, Болгар, Серби улсаар дамжин Европт очсон голдуу дөрвөдүүд

Перс	1 мянга	Хүлэгүгийн улсын ба доголон Төмөрийн аян дайнаас үлдэгсдийн хойчис
Афганистан	3200 өрх	Мөнх, Хүлэгү хаадын цэргийн үлдэгдэл, Доголон Төмөрийн ач Бабурын албат, чар, хазар, могор ястан
	/Гүн. Намсрай, Н.Билэгсайхан. Эртний эцэг өвгөд худ ураг. УБ., 2002 он номын 117 дахь талаас хэсэглэн ашиглав./	

**The reason and lesson of the migration of Mongols.
Summary**

By Chuluunbaatar L.

From the ancient times the Mongols migration traditionally were dependant from the weather condition impact and the requirements of livestock breeding. Also the political factors, such as conflict and struggle among many tribes, had an influence on this process. The migration everlasting process and also one of the basic factors of humanity. It is important to study Nomadism from new and updated concepts.

Эшлэл авсан ном зохиолын нэр

1. К.Маркс, Формы, предшествующие капиталистическому производству. К.Маркс и Ф.Энгельс. Соч, т.46, ч.1
2. Я.Цэвэл. Монгол хэлний товч тайлбар толь. УБ., 1966 он.
3. Д.Гонгор. Халх товчоон. II, УБ., 1978 он.
4. Н.Хавх. Монголын нүүдлийн мал аж ахуйн гүн ухаан. УБ., 2000 он.
5. Монголын түүхийн хураангуй хэрэглүүн. II, УБ., 1995 он.
6. Дай Юан улсын бичиг. Улаанхад хот, 1987 он.
7. Ш.Нацагдорж. Монголын феодализмын үндсэн замнал. УБ., 1978 он.
8. Я.Цэвэл. Кочевки. // Соврменная Монголия, №2, 1933 он.
9. Г.Батнасан. Методы ведения животноводство в МНР /1960-1980/, /автореферат/, УБ, 1985 г.
10. Ш.Нацагдорж. Халхын түүх. УБ., 1963 он.
11. Ч.Аръяасүрэн, Х.Нямбуу. Монгол ёс заншлын их тайлбар толь. I. УБ., 1992 он.
12. Л.Гумилёв. Кочевый быт от расцвета к исчезновению. // Азия и Африка сегодня, №2, 1969 г.
13. Ү.Нямдорж. Социализмын үед нүүдэлчин малчдын суурьших социологийн зарим асуудал. УБ., 1985 он.
14. Монгол улсын түүх /Түүх, онол-арга зүйн асуудлууд/. УБ., 1999 он.
15. Рашид-Аддин. Судрын чуулган. I боть, I дэвтэр.
16. П.Дэлгэржаргал. Мэнгу шивэй аймгийн угсаа гарлыг нэхэн сурвалжлах нь. // Түүх: ЭШБ, №188/14/. 2002 он.
17. Монголын нууц товчоо. УБ., 1990 он.
18. Б.Сумъяа. Монголын нүүдэлчдийн соёл: оршихуй, эс оршихуй. УБ., 1998 он.
19. Я.Цэвэл. Монголын үндэсний хүнс тэжээл. –Роль кочевых народов в цивилизации центральной Азии. УБ., 1974 он.
20. А.Ж.Тойнби. Постигение истории. М., 1991 г.
21. Гүн.Намсрай. Н.Билэгсайхан. Эртний эцэг өвгөд худ ураг. УБ., 2002 он.
22. Ким Жон Рэ. Их шуурганаар сийлэгдсэн түүх. Сөүл. 2001 он.